

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сэнгэбазар	Дугаар	L275
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Алаг-Эрдэнэ сум
Төрсөн газар	Алаг-Эрдэнэ сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Алаг-Эрдэнэ сумын засаг даргын тамгын газрын дарга		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цагаан бургасны хүрээ, Хатгал харуулын дуган	Сүм хийдийн дугаар	ХӨАЭ 043, ХӨАЭ 044
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Цагаан бургасны хүрээ, Хатгал харуулын дуган

Мөнхбат: За ингээд Алаг-Эрдэнэ сумын төвийн зүүн хойд талын тэр дэвсгэр дэнж дээр байрлаж байгаа энэ шинээр босгосон суварганы талаас эхлээд, одоо тус сумын нутаг дэвсгэр дээр байгаа сүм хийдийн туурийн талын одоо судалгаагаа эхлэе.Тэгэхээр та эхлээд энэ суварганы талаар хэрхэн яаж босгосон юм, хэзээ босгосон юм, ямар зорилгоор босгосон юм, одоо энэ суварга байгаа дэнжийг ямар нэртэй дэнж гэдэг юм, энийг одоо босгож бүтээсний зорилго чиглэлээ хэлж танилцуулна уу?

Сэнгэбазар: За тэгэхээр манай сумын наян жилийн ой 2006 онд болсон юм. За энэ ойг угтаж одоо МУГЖ Цэрэндарьзав гуай энэ сумын уугуул.За энэ хүн одоо Цагаан бургасны хүрээний туурин дээр би нэг суварга босгоё гэж анх санаачилгыг нь бол гавъяат Цэрэндарьзав гуай гаргасан.За ингээд бид одоо энэ Цагаан бургасны туурин дээр суварга босгохоор хандив, дэм цуглуулу, ард түмнээрээ ярилцаж ийм ажлыг зохион байгуулсан.Аа гэтэл ард түмэн бол одоо энэ олны хүртээл болгож жинхэнэ мөргөлийн газар болгож, хүмүүсийнхээ шашин шүтлэг аливаа юмыг нь бодолцоод сумын төв дээрээ байлгавал яасан юм бэ гэсэн ийм санал санаачилга гараад

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ингээд сумын төв дээрээ энэ суваргыг босгосон.За энэ суваргыг анх одоо санаачилсан хүн нь бол гавъяат жүжигчин Цэрэндарьзав гуай.Аа энийг бүтээсэн хүн нь бол одоо Алаг-Эрдэнэ сумын харъяат уран Ганбаа гэдэг хүн одоо хийж бүтээсэн.За энийг одоо шившлэх, аравнайлах тэр Бурхан багшийн бодь гэдэг нэртэй ийм суварга юм. Энэ Бурхан багшийн бодь суваргыг анх бүтээсэн хүн нь бол тэр аравнайлах, тэр бурхан шашны талаас нь хийж гүйцэтгэсэн хүн нь одоо Эрдэнэ-Очир гэдэг лам бий, Мөрөнгийн.Ийм хүмүүс байгаа. Тэгээд одоо урагшаа Энэтхэг, Утай Гүмбэн талаас бол бүх юмыг нь авчирч шүншиглэж хийсэн.За энэ ажлыг бүтээхэд ний ард иргэд, албан байгууллага, Улаанбаатар хотын нутгийн зөвлөл, Дархан, Эрдэнэтийн нутгийн зөвлөл, Мөрөнгийн нутгийн зөвлөлөөс нийт 4,6 сая төгрөг боссон.Ийм учиртай. За зүгээр энэ суварганы байгаа дэнжийг бол тодорхой нэг их нэрлэдэггүй.Зүгээр яахав, Алаг-Эрдэнэ сумын төв дээр байгаа л гэсэн ийм ойлголттой байдаг.Зүгээр энэ хойно байгаа бор уулыг бол Ужигийн овоо гэдэг.Энэний одоо баруун суганд ингэж баригдсан ийм юм байгаа юм аа.

Мөнхбат: Энгэ урд талын уулыг, модтой?

Сэнгбазар: Хавиргын даваа.

Мөнхбат: Хавиргын даваа?

Сэнгбазар: Тийм, Хавиргын даваа.Энэ Хавиргын давааг даваад л Цагаан бургасны хүрээ орно.

Мөнхбат: Зүүн талын уулыг, одоо энэ зүүн талын ам л юм даа, тийм ээ, доод талын ам?

Сэнгбазар: Тийм, тэр Харганы ам гэж байгаа.

Мөнхбат: Харганы ам?

Сэнгбазар: Тийм, Харганы ам гэж нэрлэж байгаа.

Мөнхбат: Ужигийн овоо орон нутгийн тахилгатай юу?

Сэнгбазар: Тахилгатай.Одоо энэ жил 6 сарын 17-ны өдөр тахилга хийх гээд бид Мөрөнгөөс лам хуваргаа ярьчихсан, одоо таван лам ирнэ.Энэ үеэр тэр ой энэ тэр болох гээд давхар том баяр болох гэж байгаа.Ийм учиртай юм аа.

Мөнхбат:За тэгэхээр ингээд ямар ч байсан сумын наян жилийн жилийн ойг тохиолдуулаад сум дээрээ сүсэгтэн олны эргэлд мөргөлийн газар болгох зорилгоор энэ Бурхан багшийн бодь суваргыг бүтээжээ.За бид нар одоо ингээд энэ суварга дээр хэмжилтүүдээ хийгээд, байр зүйг нь тододрхойлоод, өндөр өргөн энэ утга агуулга дүрслэлийг нь бол хэмжиж тэмдэглэж авах юм аа.

Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ сум, Хатгал харуулын дуган

Мөнхбат: За бид нар Алаг-Эрдэнэ сумын төвөөс хойш хорь орчим км-т байх тус сумын гуравдугаар багийн нутаг Адууны ам хэмээх ийм газар байх нэгэн хийдийн түүрин дээрээс судалгааны ажлаа үргэлжлүүлж байна.За энэ хийдийн нэр болохоор Хатгал харуулын дуган гэж ийм нэрээр Ренчин гуайн Буддын сүм хийдийн жагсаалтанд орсон байгаа.За энэ хийдийн түүх, үүсэл гарал, одоо ямар хурал хурж байсан, за энэ хийдийн цаг төрийн ороо бусгаа тэр цагт мянга есөн зуун гучаад оны дунд үеэс эхлэн хэрхэн яаж мөхсөн энэ тухай тус сумын засаг даргын тамгын газрын дарга одоо яриагаа үргэлжлүүлж байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сэнгбазар: За Хатгал харуулын дуган 1889 онд одоо Алаг-Эрдэнэ сумын хоёрдугаар багийн нутаг, юу...

Мөнхбат: Адууны ам?

Сэнгбазар: Биш ээ, хоёрдугаар багийн Мухрын давааны нутагт анх байгуулж байсан юм байна лээ. За ингээд наян есөн онд тэнд гэр дугантай Мухрын давааны аманд байж байгаад 1902 онд одооны байгаа тэр Эгийн голын захад, зүүн дэнж дээр Адууны ам гэдэг газар төвлөрч, энд одоо сүм дуганаа барьж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. За ингээд 1910 оны орчим одоо наймдугаар дүрийн Богд Жавзандамба хутагтаас Дэчиндаржаалин сүм гэж нэр шагнагдаж байсан байна. За тухайн үедээ энд нэг тавь орчим лам ингэж байнгын хурал ном хурж суудаг байсан. За гэхдээ одоо энд майдар бурхан эргэдэг, цам мөн бүжиглэдэг ийм дуган байсан гэж хөгшчүүл ярьдаг юм байна лээ. Сүүлийн үед одоо бас л ялгаа байхгүй, Цагаан бургасны хүрээтэй нэгэн адил гучин долоон оны орчим, гучин есөн оны сүүлийн үед энэ үеэр бас одоо тэнд байсан лам нарыг хоморголон устгаж, за сүм дуганыг нь шатааж устгасан гэсэн ийм яриа хөөрөө байдаг. За эндээс зүгээр одоо Адууны амаар дайраад явахад, голоо гараад голынхоо нөгөө талд байгаа учраас та нар бол нэг их очиж чадахгүй байх. Аа наанаас нь бол харж болно. Тэнд бол уул нь зүгээр туурь гэхээр юм бий. Харин юу ч үгүй тийм юм байхгүй. Зүгээр энд нь ийм дуган байсан юм, тийм сүм байсан юм гээд хүмүүсүүд нь бол мэддэг улсууд нь заагаад байх юм байна лээ. Тийм юмнууд бол байдаг, тэнд нь. Тэгээд сүүлд нь тэнд бас Алаг-Эрдэнэ сүм, бас голын нөгөө талд нь анх байгуулагдаж, сургуулийн сургууль чинь тэнхим нэртэй. Анх хорин хүүхэдтэй тэнхим байгуулагдаж байсан юм байна лээ л дээ. Тэгэхээр яг тэр одоо Хатгалын харуулын дуганын суурин дээр сүм тэнхим байгуулагдаж байсан ийм түүхтэй юм. Ийм учиртай байгаа юм. Тэгээд энэнээс цаашаа бас өөр тодорхойг мэдэхгүй байна аа.

Мөнхбат: За таны ярьсан энэ яриа бидэнд өгсөн энэ үнэтэй мэдээлэл монголын буддын шашны сүм хийдийн төслийн судалгаа хэмээх манай судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. За ингээд танд баярлалаа. Таны цаашдын ажил үйлсд улам өндөр амжилтыг хүсэн ерөөе өө.

Сэнгбазар: За баярлалаа.

Мөнхбат: За Адууны аман тушаа Эгийн голыг гараад явах одоо тийм гүүр, өөр одоо бусад ямар нэгэн юм байхгүй. Гарам байхгүй, машин гарах бололцоогүй байсан учраас бид нар Адууны аман дээр очиж одоо зураг авалт хийж чадаагүй ээ гэдгийг хүсцэл өчье. Уг нь тэнд очсон бол энэ Хатгал харуулын дуганы туурийг авах тийм боломжтой байсан юм аа.

Хатгал харуулын дуган

Мөнхбат: За бид нар Алаг-Эрдэнэ сумын төвөөс хойш хорь орчим км-т байх тус сумын гуравдугаар багийн нутаг Адууны ам хэмээх ийм газар байх нэгэн хийдийн туурин дээрээс судалгааны ажлаа үргэлжлүүлж байна. За энэ хийдийн нэр болохоор Хатгал харуулын дуган гэж ийм нэрээр Ренчин гуайн Буддын сүм хийдийн жагсаалтанд орсон байгаа. За энэ хийдийн түүх, үүсэл гарал, одоо ямар хурал хурж байсан, за энэ хийдийн цаг төрийн ороо бусгаа тэр цагт мянга есөн зуун гучаад оны дунд үеэс эхлэн хэрхэн яаж мөхсөн энэ тухай тус сумын засаг даргын тамгын газрын дарга одоо яриагаа үргэлжлүүлж байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сэнгбазар: За Хатгал харуулын дуган 1889 онд одоо Алаг-Эрдэнэ сумын хоёрдугаар багийн нутаг, юу...

Мөнхбат: Адууны ам?

Сэнгбазар: Биш ээ, хоёрдугаар багийн Мухрын давааны нутагт анх байгуулж байсан юм байна лээ. За ингээд наян есөн онд тэнд гэр дугантай Мухрын давааны аманд байж байгаад 1902 онд одооны байгаа тэр Эгийн голын захад, зүүн дэнж дээр Адууны ам гэдэг газар төвлөрч, энд одоо сүм дуганаа барьж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. За ингээд 1910 оны орчим одоо наймдугаар дүрийн Богд Жавзандамба хутагтаас Дэчиндаржаалин сүм гэж нэр шагнагдаж байсан байна. За тухайн үедээ энд нэг тавь орчим лам ингэж байнгын хурал ном хурж суудаг байсан. За гэхдээ одоо энд майдар бурхан эргэдэг, цам мөн бүжиглэдэг ийм дуган байсан гэж хөгшчүүл ярьдаг юм байна лээ. Сүүлийн үед одоо бас л ялгаа байхгүй, Цагаан бургасны хүрээтэй нэгэн адил гучин долоон оны орчим, гучин есөн оны сүүлийн үед энэ үеэр бас одоо тэнд байсан лам нарыг хоморголон устгаж, за сүм дуганыг нь шатааж устгасан гэсэн ийм яриа хөөрөө байдаг. За эндээс зүгээр одоо Адууны амаар дайраад явахад, голоо гараад голынхоо нөгөө талд байгаа учраас та нар бол нэг их очиж чадахгүй байх. Аа наанаас нь бол харж болно. Тэнд бол уул нь зүгээр туурь гэхээр юм бий. Харин юу ч үгүй тийм юм байхгүй. Зүгээр энд нь ийм дуган байсан юм, тийм сүм байсан юм гээд хүмүүсүүд нь бол мэддэг улсууд нь заагаад байх юм байна лээ. Тийм юмнууд бол байдаг, тэнд нь. Тэгээд сүүлд нь тэнд бас Алаг-Эрдэнэ сүм, бас голын нөгөө талд нь анх байгуулагдаж, сургуулийн сургууль чинь тэнхим нэртэй. Анх хорин хүүхэдтэй тэнхим байгуулагдаж байсан юм байна лээ л дээ. Тэгэхээр яг тэр одоо Хатгалын харуулын дуганын суурин дээр сүм тэнхим байгуулагдаж байсан ийм түүхтэй юм. Ийм учиртай байгаа юм. Тэгээд энэнээс цаашаа бас өөр тодорхойг мэдэхгүй байна аа.

Мөнхбат: За таны ярьсан энэ яриа бидэнд өгсөн энэ үнэтэй мэдээлэл монголын буддын шашны сүм хийдийн төслийн судалгаа хэмээх манай судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. За ингээд танд баярлалаа. Таны цаашдын ажил үйлсд улам өндөр амжилтыг хүсэн ерөөе өө.

Сэнгбазар: За баярлалаа.

Мөнхбат: За Адууны аман тушаа Эгийн голыг гараад явах одоо тийм гүүр, өөр одоо бусад ямар нэгэн юм байхгүй. Гарам байхгүй, машин гарах бололцоогүй байсан учраас бид нар Адууны аман дээр очиж одоо зураг авалт хийж чадаагүй ээ гэдгийг хүсцэл өчье. Уг нь тэнд очсон бол энэ Хатгал харуулын дуганы туурийг авах тийм боломжтой байсан юм аа.

Цагаан бургасны хүрээ

Мөнхбат: За бид нар Алаг-Эрдэнэ сумаас зүүн урагшаа хорин дөрөв, таван км-т байрлах энэ нутаг хошууны газар, нутгийн хил дотор байрладаг, академич Ренчин гуайн Монголын буддын шашны сүм хийдийн жагсаалтад орсон Цагаан бургасны хүрээ хэмээх энэ хурал номын газрын туурийн сурвалжлагыг хийж байна. За тэгэхээр сумын засаг даргын тамгын газрын дарга танаас одоо Цагаан бургасны хүрээний түүх хөгжил, одоо ид бурхан номын мандан бадарч байх тэр цаг үедээ хичнээн ламтай байсан юм, ямар ямар одоо хурал хурдаг байсан юм. Ямар одоо шүтээн сахиустай байсан юм энэ талаар одоо хариулж өгнө үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сэнгбазар: За Цагаан бургасны хүрээний хувьд бол 1779 онд гэр дугантай байсан юм гэж түүхэнд байдаг юм байна лээ. За ингээд 1805 онд модон дуган барьж цогчин хүрж эхэлсэн. Энэ үеэс одоо Богд хаанаас Дашпунцаглин гэж нэр шагнаж байсан. Ийм нэртэй, ийм хийд сүм дуган байсан юм байна лээ. За энэ дуган, энэ сүм хүрээ хийдэд нийтдээ нэг гурван зуу орчим ламтай, зуу гаруй цам гардаг байсан гэж ингэж түүхэнд бичигдсэн байдаг. За ер нь зүгээр Цагаан бургасны хүрээ, Хатгалын Харуулын дуган болвол маш их бага одоо цам бүжиглэдэг, цам гаргадаг ийм хүрээ дуган байсан байна. За харамсалтай нь 1937 онд хоморголон устгах их баривчилгаа болж, одоо тэр Цагаан бургасны хүрээнд байсан гурван зуу гаруй лам нараас, лам нарыг одоо бүгдийг нь шаргалтуулан түүж аваачаад Хатгалын хойд талын улаан модонд устгаж байсан гэж ингэж манай хөгшчүүл ярьдаг. Зүгээр одоо тэр миний яриад өнгөрсөн тэр суварга бүтээх санаачилгыг гаргасан тэр гавъяат Цэрэндарьзав гуайн аав нь тэр Цагаан бургасны хүрээнд сууж байгаад баривчлагдаж, энд одоо энэ Цагаан бургасны хүрээний хойд талын одоо дэвсэгийн дэнж гэдэгт нуугдаж үлдэж тэгээд сүүлд одоо арван жилээр хоригдох ял авч байсан юм байна лээ л дээ. Тэр мэрийгээ бодоод тэр Цэрэндаржаа гуай энэ суваргыг босгох санаачилгыг гаргасан гэж өөрөө ярьдаг юм аа. За ийм л юм байна даа, энэ талаар бол өөр одоо тодорхой сайн мэдэх юм. Үгүй одоо болвол ерөөсөө энд юу ч байхгүй. Зүгээр яг энд байсан гээд мэддэг хүнээр би заалгасан. Зүгээр одоо тэр манай арслан, улсын арслан Мөнх-Эрдэнэгийн хадам Сүрэн гэж хөгшин бий л дээ. Одоо Улаанбаатар хотод байгаа. Тэр хөгшин үүл нь Алаг-Эрдэнэнийн харъяат байж байгаад Рашаант руу шилжиж очоод. Тэгээд одоо Рашаантын харъяат гэж Мөнх-Эрдэнэ арслан явдаг. Тэгээд тэр Мөнх-Эрдэнэ арслангийн хадам гээчтэй би ноднин хот орохдоо үулзаж байсан. Тэгээд тэр хөгшин бол их сайн мэддэг юм байна лээ, ерөөсөө. Одоо бол харамсалтай нь тэнд үнэхээр ганц шон ч байхгүй тийм газар байна лээ.

Мөнхбат: За тэгэхээр хэдийгээр одоо өнөөдөр шон, үл мөр юу ч үлдээгүй ч гэсэн энэ хүрээ цагтаа одоо шашин төрийнхөө ид мандан бадралын үед гурван зуу гаруй лам нарын хурал хүрж шашны төрлийн бүхий л зан үйлийн арга хэмжээ энд явагддаг байсан нь таны ярианаас тодорхой байна аа. Тэгээд Алаг-Эрдэнэ сүмийн бас нэг бид нарын ажигласнаар, анх одоо ажигласан нэг том онцлог бол бусад сумуудад байж байгаад бас үрэн таран хийгээд байхгүй болсон аль эсвэл нэг газрын нэг одоо засаг даргын тамгыг газрын өрөөнд одоо тоосонд харанхуйд чийгэнд дарагдаад хэвтэж байдаг сүмийн түүхэнд холбогдох томоохон баримтууд фото зургууд үзмэрүүдээ одоо бас ингэж тусад нь нэг байранд өрөө гаргаад ийм зориулалтын маягаар ашиглах гэж бас сүм орныхоо түүхийг гадна дотны зочид гийчид мөн содоо үр хүхэд, ирээдүй хойч үедээ таниулах зорилгоор сүмийн музейг байгуулж байгаа нь одоо их сайшаалтай санагдсан. Тэгээд энэ музей дотроос манай судалдгааны багийнхан Цагаан бургасны хүрээний одоо арванесдүгээр зууны сүүлч үе хорьдугаар зууны эхэн үеэс одоо хичнээн сүм дугантай байсан юм, ямархуу одоо тэг гортигтой байсан юм, ямар ямар одоо барилга байшингууд буддын шашны үр хийц бүхий ийм байшингууд тэнд байсныг дүрслэн харуулсан ийм уран зургийг, уран зураг байсныг бид нар одоо фото зургаараа авч баримтжуулсан. За мөн бид, сая одоо энэ дээр уран зураг гэж хэллээ. Гэхдээ энэ бол түүхэн баримтанд тулгурласан, түүхэн үнэнд ойртуулахыг хичээсэн. Одоо тэр хүрээнд идэр залуудаа хүүхэд ахуйдаа шавилан сууж байсан орон нутгийн өндөр настангууд, одоо тэр хүрээг мэдсэн, мэдэх

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ийм хүмүүсийн аман яриагаар одоо ингэж зохиомжилж хийсэн гэдгийг засаг даргын тамгын газрын дарга Сэнгэбазар гуай бидэнд өгүүлж байсан.За ийм байна.